

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2023 оны 12 дугаар сар

АГУУЛГА:

1. Аж үйлдвэр
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр



▶ ЭДИЙН ЗАСАГ 2023 ОНД

ДНБ-ий өсөлт

(2023 оны III улирал)

6.9 хувь

*2023 оны эцэст эдийн засаг 6.8 хувиар өсөхөөр төсөөлж байна.

Валютын нөөц

(2023 оны эцэс)

4.9 тэрбум \$

Инфляц

(2023 оны эцэс)

7.9 хувь

Төсвийн тэнцэл

(2023 оны эцэс)

763 тэрбум ₮

Экспорт

(2023 оны эцэс)

15.2 тэрбум \$

Импорт

(2023 оны эцэс)

9.3 тэрбум \$

ГШХО

(2023 оны эхний 3 улирал)

1.9 тэрбум \$

Зээлийн хүү

(2023 оны II сар)

16.6 хувь

Ажилчдын тоо

(2023 оны III улирал)

1.2 сая

*III улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 59 хувь байна.

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2023 оны эцэс)

96.8 мянга


*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.



Аж үйлдвэрийн салбар 2023 онд сэргэхэд нүүрс, газрын тос, зэсийн баяжмал зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Мөн махны экспортын квотыг цуцалснаар мах боловсруулалт нэмэгдлээ.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(их наяд төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ

(өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, тооцоолол


УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

(голлох бүтээгдэхүүнээр)

Хүнийл	2023 онд	Өмнөх ондоо өөрчлөлт
Нүүрс	81.2 сая тонн	2.2 дахин
Зэсийн баяжмал	1,395 мян.тонн	17%
Газрын тос	4.9 сая баррель	1.9 дахин
Алт	14.9 тонн	-23%
Төмрийн хүдэр	7.6 сая тонн	-19%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2023 онд 30.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 45 хувиар өслөө.
- Нүүрс, газрын тос олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл 50 хувиар өссөн нь гол нөлөөлөв.
- Бүх төрлийн махны экспортын квотыг цуцалснаар мах боловсруулах үйлдвэрлэл нэмэгдэж, боловсруулах салбар 37 хувиар өссөн байна.

БОДИТ ҮЙЛДВЭРЛЭЛ

- Аж үйлдвэрийн салбарын бодит үйлдвэрлэл 2023 онд өмнөх оноос 27.5 хувиар өсөөд байна. Үүнээс, уул уурхайн салбар 37 хувиар, боловсруулах салбар 16 хувиар өслөө.
- Боловсруулах салбарын өсөлтөд мах боловсруулах үйлдвэрлэл 2.4 дахин нэмэгдсэн нь нөлөөлөв.

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

- Нүүрс олборлолт 2023 онд 81.2 сая тоннд хүрч өмнөх оноос 2.2 дахин нэмэгдлээ.
- Оюутолгойн гүний уурхай 3-р сард ашиглалтад орж, нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 17 хувиар нэмэгдлээ.
- Газрын тос олборлолт өмнөх оны сүүлийн хагасаас эхлэн хэвийн үргэлжилж, 2023 онд жилийн дүнгээр 1.9 дахин нэмэгдээд байна.
- Харин алт, төмрийн хүдэр олборлолт 23 болон 19 хувиар тус тус буурсан байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС


- Үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 5 хувь, цар тахлын өмнөх үеэс 70 хувиар тус тус өслөө. Салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн индексийг харвал:
 - Уул уурхайн үйлдвэрлэлийнх 24 хувиар,
 - Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийнх 16 хувиар,
 - Ундаа, согтууруулах ундааны үйлдвэрлэлийнх 13 хувиар,
 - Нэхмэлийн үйлдвэрлэлийнх 10 хувиар тус тус өссөн байна.



Экспорт нэмэгдсэний үр дүнд 2023 оны эцэст гадаад худалдааны тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 35 хувиар өслөө. Худалдааны түнш орнуудад инфляц буурсны дүнд манай улсын импортын барааны үнэ тогтвортой байсан нь худалдааны тэнцэл нэмэгдэхэд эерэг нөлөөтэй байв.

ЭКСПОРТ


(тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

(тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТ


- 2023 оны байдлаар экспорт 15.2 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар өссөн байна.
- Нийт экспортын 58 хувийг нүүрсний экспорт дангаараа бүрдүүлж байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ

- Хилийн боомтуудын тээвэр зохион байгуулалт сайжирснаар нүүрсний экспортын орлого 8.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 29 хувиар өслөө.
- Оюутолгойн баямжал дахь алтны агууламж багассанаас шалтгаалан зэсийн баямжлын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар буурлаа.

ИМПОРТ

(тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ

(тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ИМПОРТ

- 2023 оны байдлаар импорт 9.3 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өссөн байна.
- Худалдааны түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжсоноор импортын өсөлтийн 16 хувийг үнийн өсөлт, 84 хувийг биет хэмжээний өсөлт бүрдүүлж байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ


- Тоног төхөөрөмжийн импорт 1.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 42 хувиар өслөө.
- Хүнсний бүтээгдэхүүний импорт 1.0 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 10 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС

(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

НҮҮРС

- Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2023 оны дундаж үнэ 296 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 19 хувиар буурсан байна.

ЗЭС

- Лондоны бирж дэх цэвэр зэсийн үнэ 2023 оны дундажаар 8,523 ам.доллар болж, өмнөх оноос 3 хувиар буурсан байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхөйд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Брент)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

- Зүүнхөйд Хятад дахь төмрийн баяжмалын 2023 оны дундаж үнэ 121 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 1 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС


- Брент газрын тосны 2023 оны дундаж үнэ 79 ам.долларт хүрч өмнөх оны эцсээс 1 хувиар буурлаа.



УУББ-ээр 2023 онд нийт 14.9 сая тонн нүүрс, 678 мянган тонн төмрийг анхны үнээс дунджаар 8 хувиар өсгөн арилжаалсан. Уул уурхайн бүтээгдэхүүний худалдаа биржийн тогтолцоонд шилжсэнээр ашигт малтмалын борлуулалтын үйл ажиллагаа ил тод болж, баялгийг зах зээлийн бодит үнээр худалдаалах боломж бүрдлээ. 2024 оны 1 дүгээр сарын 17-ны байдлаар 2024 онд 214 мянган тонн нүүрс, 59 мянган тонн төмрийг арилжааллаа.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА


(сая тонн, сараар)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн, сараар)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ АРИЛЖАА


- 2023 онд нийт 14.9 сая тонн нүүрс арилжиж, 7.4 их наяд төгрөг буюу 2.1 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Гадаад эрэлт сайн байснаар 12 дугаар сард 3.4 сая тонн нүүрс борлуулсан нь 2023 оны хамгийн их борлуулалттай сар байв.
- 2024 оны 1 дүгээр сарын 17-ны байдлаар 214 мянган тонн нүүрс арилжиж, 28 сая ам.долларын орлого олжээ.

ТӨМРИЙН АРИЛЖАА

- 2023 оны 9 дүгээр сараас төмрийн хүдэр, баяжмалыг биржээр арилжаалж эхэлсэн ба 2023 онд нийт 677.5 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг арилжаалж, 196 тэрбум төгрөг буюу 57 сая ам.долларын борлуулалт хийлээ.
- 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 59 мянган тонн төмрийг арилжаалж, 5 сая ам.долларын орлого олжээ.

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

НҮҮРСНИЙ ҮНЭ

- УУББ-ээр 9 төрлийн нүүрсийг арилжаалж байгаа ба 12 дугаар сарын дуудах дундаж үнэ 153 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 164 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 12 дугаар сард хэлцлийн доод үнэ 31 ам.доллар, дээд үнэ 210 ам.долларт хүрсэн ба дундаж үнэ 164 ам.доллар байна.

НҮҮРСНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ

- 2023 онд нүүрсний хэлцлийн үнэ анхны дуудсан үнээс дунджаар 8.3 хувиар өссөн байна.
- 12 дугаар сард хийгдсэн нүүрсний арилжааны дундаж үнэ анх дуудсан үнээс 6.7 хувиар өссөн нь өмнөх сарын дундажаас доогуур байна.




Засгийн газраас авч хэрэгжүүлж буй гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд уул уурхайн экспортын орлого өссөнөөр төлбөрийн тэнцлийн ашиг 1.0 тэрбум ам.долларт хүрч, 2023 оны эцэст төсөв болон төлбөрийн тэнцэл 13 жилийн дараа нэгэн зэрэг ашигтай гарахаар хүлээгдэж байна. Гадаад валютын улсын нөөц түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэнээр төгрөгийн ханш тогтворжив.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Төлбөрийн тэнцэл 2023 оны эхний 11 сард 964 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 2.2 тэрбум ам.доллараар сайжирлаа.
- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 4.4 тэрбум ам.доллараар нэмэгдэж, урсгал дансны ашиг эхний 11 сард түүхэн дээд түвшинд буюу 481 сая ам.долларт хүрлээ.
- Шууд хөрөнгө оруулалтын орох урсгал 2023 оны эхний 11 сард 1,333 сая ам.доллар болж, өмнөх оноос 136 сая ам.доллараар буурсан байна.

- Гадаад валютын улсын нөөц 2023 оны эцсийн байдлаар түүхэн дээд түвшин болох 4.9 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 тэрбум ам.доллараар буюу 44.7 хувиар нэмэгдлээ.

- 2023 оны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3,411 болж, оны эхнээс 37 төгрөгөөр буюу 1.1 хувиар чангарлаа.
- Гадаад валютын нөөц нэмэгдсэнээр төгрөгийн ханш тогтворжиж, ханш 2022 онд өдөрт дунджаар 2.6 төгрөгөөр суларсан бол 2023 онд 0.1 төгрөгөөр чангарлаа.

- Төв банк 2023 онд нийт 3.9 тэрбум ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлсэн нь 2022 оноос 1.1 тэрбум ам.доллар буюу 21.4 хувиар бага байв.
- Оны эхний хагаст 1.7 тэрбум ам.доллар, сүүлийн хагаст 2.2 тэрбум ам.долларыг зах зээлд нийлүүлж, оны сүүлийн хагаст дуудлага худалдаа нэмэгдлээ.



Инфляц 12 дугаар сарын гүйцэтгэлээр 7.9 хувь гарч, төв банкны зорилтот түвшинд оров. Экспортын орлого, гадаад валютын албан нөөц нэмэгдэж, төгрөгийн ханш тогтворжсонтой холбоотойгоор импортын инфляц аажмаар буурч байна. Харин дотоодын цөөн голлох бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцын 40 орчим хувийг бүрдүүлж байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

САРЫН ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


- 2023 оны 12 дугаар сард улсын жилийн инфляц 7.9 хувьд хүрч төв банкны зорилтот түвшинд орлоо.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.8 нэгж хувь (35.3%)-ийг бүрдүүлж байна.

САРЫН ИНФЛЯЦ

- 2023 оны 12 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.4 хувиар өсөв.
- Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх өсөхөд хүнсний бүлэг голлон нөлөөлсөн бөгөөд 70 хувийг бүрдүүлж байна.
- Сарын инфляцад хонины мах 33%, сүү 14%, талх, гурил, будаа 12%-ийг бүрдүүлж байна.

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ЭЗХЯ-ны тооцоолол

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

СУУРЬ ИНФЛЯЦ

- Суурь инфляцыг нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцдог.
- Суурь инфляц 12 дугаар сард 6.7 хувь гарч, нийт инфляцын 4.5 нэгж хувийг бүрдүүлжээ.
- Суурь инфляц сүүлийн 4 сар дараалан буурч зорилтот инфляцын түвшинд орлоо.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 12 дугаар сард жилийн инфляцын 38 гаруй хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 16.9 хувиар өсжээ.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өсөв.



Монгол Улсын нэгдсэн төсөв 2018 оноос хойш анх удаа ашигтай гарлаа. Ашигт малтмалын тээвэрлэлт, экспортлох үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулж, уул уурхайн биржийн тогтолцоог нэвтрүүлсний үр дүнд АМНАТ өнгөрсөн оны мөн үеэс 43 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүллээ.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ОРЛОГО

(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ


- Нэгдсэн төсөв 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 0.8 их наяд төгрөгийн ашигтай гарлаа.
- Экспорт сэргэж, эдийн засгийн идэвхжил эрчимжсэн нь голлон нөлөөлөв.

ТӨСВИЙН ОРЛОГО

- Орлого 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 5.8 их наяд төгрөг буюу 30 гаруй хувиар нэмэгдсэн байна.
- Орлогын албан татвар 1.9 их наяд, АМНАТ 1.3 их наяд, НӨАТ 0.9 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2023 онд нэмэгдсэн голлох ЗАРЛАГУУД


(зарлагын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Зарлага 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 22.5 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 4.3 их наяд төгрөг буюу 23.7 хувиар нэмэгдсэн байна.
- 2023 оны төсвийн тодотголоор цалин хөлс 994 тэрбум төгрөгөөр, өндөр насны болон халамжийн тэтгэвэр, тэтгэмж 529 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

- Засгийн газрын өр 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30.8 их наяд төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 43.7 хувьд хүрээд байна.
- 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр Засгийн газрын өр (ӨҮЦ)-ийн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.8 хувиар өссөн байна. Үүнд, төгрөгийн хадгаламж 36 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ (их наяд төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХАДГАЛАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ (их наяд төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

- Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 37.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 26.8 хувиар өссөн байна. Үүнд, төгрөгийн хадгаламж 36 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

ХАДГАЛАМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ


- Нийт хадгаламж 22.1 их наяд төгрөгт хүрч хүрч өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 17.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 36 хувиар, өмнөх сараас 7.6 хувиар өсөв.
- Гадаад валютын хадгаламж 5.0 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээнд хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар, өмнөх сараас 2.9 хувиар өсөв.

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (их наяд төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХҮҮГИЙН ТҮВШИН (жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЗЭЭЛ

- Банкнүүдн зээлийн үлдэгдэл 2023 оны 12 дугаар сард 27.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24 хувиар өсөв.
- Чанаргүй зээлийн үлдэгдэл 2.0 их наяд төгрөг байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 7.4 хувь буюу өнгөрсөн оноос 1.7 нэгж хувиар буурсан байна.


ХҮҮГИЙН ТҮВШИН

- Банкнүүдн зээлийн жигнэсэн дундаж хүү 2023 оны 11 дугаар сард 16.7 хувь болж өмнөх оноос 1.0 нэгжээр өсөв.
- Банкнүүдн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2023 оны 12 дугаар сард 11.6 хувь болж өмнөх оноос 0.7 нэгжээр өсөв.



Эдийн засаг идэвхжиж сүүлийн зургаан улирал дараалан эерэг өсөлттэй байгаа ч хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт цар тахлын өмнөх түвшнээс бага хэвээр байна. Мөн сүүлийн 4 улирал дараалан ажиллах хүч буурч, ажиллах хүчнээс гадуурх хүн ам тэлж байгаа нь иргэдийн ажил хийх сонирхол буурч байгааг харуулж байна.

АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ (мянган хүн)



АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН (хувь)



АЖИЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

- Ажилчдын тоо 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 1.2 саяд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 мянган хүнээр нэмэгдсэн ч өсөлтийн хурд бага байна.
- Ажилчдын тооны өсөлтөд, уул уурхай, эрчим хүч, тээвэр, барилгын салбарын ажилчид эергээр нөлөөлсөн.
- Харин үйлчилгээ, боловсруулах, мэдээлэл холбоо, хөдөө аж ахуйн салбарын ажилчид сөргөөр нөлөөллөө.


АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

- Ажиллах хүчний оролцооны түвшин 58.9 хувьд хүрсэн ч цар тахлын өмнөх үеэс 1.2 нэгж хувиар доогуур байна.
- Ажилгүй иргэдийн тоо 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 2 мянган хүнээр буурч, 66 мянгад хүрлээ.

ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ ААНБ (мянга)



ДУНДАЖ ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

- Дундаж цалингийн хэмжээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 27.3 хувиар өсөж, 2,009 мянган төгрөгт хүрлээ.
- Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж, улсын дунджаас 2.4 дахин өндөр байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ ААНБ

- Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 2023 онд 96.8 мянгад хүрч өмнөх оноос 5 мянгаар нэмэгдсэн байна.
- Уг өсөлтөд худалдаа, үйлчилгээний салбарын 1-9 ажилтантай ААНБ-уудын тоо нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ